

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр

№ 20/32

Улаанбаатар хот

**Зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх
эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.23 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН банкнаас авсан зээлийн гэрээний хугацааг доорх нөхцөлийн дагуу сунгах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д олгосугай.

Зээлийн хэмжээ	1.4 (нэг аравны дөрвөн) тэрбум төгрөг
Зээлийн хэлбэр	Овердрафт
Зээлийн сунгаж буй хугацаа	12 (арван хоёр) сар
Зээлийн хүү, шимтгэл	Зээлийн хүү жилийн 19.2%, Зээлийн шимтгэл 1.2 (нэг аравны хоёр) сая төгрөг
Эргэн төлөх нөхцөл	Зээлийн хүүгийн төлбөр сар бүр, үндсэн төлбөр банктай тохирсон нөхцлийн дагуу
Барьцаа хөрөнгө	1.4 (нэг аравны дөрвөн) тэрбум төгрөгийн хэвийн зээлийн багц болгон нэмэгдүүлэх болон Харилцах дансны орлого үргэлжлүүлэн барьцаалах

2. Зээлийн гэрээний хугацааг сунгах асуудлаар ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН банкинд хүсэлт гаргах, зээлийн судалгаанд шаардлагатай мэдээлэл, материалыг бүрдүүлж, хүргүүлэх, зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн болон Барьцааны нэмэлт гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д олгосугай.
3. ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН банктай байгуулсан Зээлийн гэрээний нэмэлт гэрээний талаар, Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.
4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

ЛЭНДМН ББСБ

/Ц.ОДМАА/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

/О.БОЛДБААТАР/

/Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

/В.БАЯРСАЙХАН/

/С.БОРГИЛ/

/С.ЭНХ-АМГАЛАН/

/Н.ЦЭВЭГМИД/

/Ч.НОМИН/

/Ж.ЖАРГАЛСҮРЭН/